

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
МОНГОЛ ХЭЛ СОЁЛЫН СУРГУУЛЬ
эрдэм шинжилгээний бичиг

Том. XXXIII (359)

2011

9-13


МОНГОЛ ХЭЛНИЙ “НАР ЗӨВ, НАР БУРУУ” ХЭМЭЭХ
ХЭЛЛЭГИЙН УЧИР

Д.Бадамдорж*


Монголчууд наран, саран, одон гурвыг маш эртнээс янагш шүтэж, илчийг нь амьдрал ахуйдаа шингээж ирсэн бололтой байна.

Монгол аман зохиолоос сурвалжилж үзвэл, “Нар зөв эрчилсэн хуй бол бурхны тоос, нар буруу эрчилсэн хуй бол чөтгөрийн тоос” (1:106) хэмээх бэлгэшээл цээрлэл хосолсон утгат зүйр үг бидний сонирхлыг татаж байна. Эл зүйр үгийн утга бол хуй салхи цагийн зүүний дагуу буюу нар зөв эрчилсэн байвал эерэг, цагийн зүүний эсрэг буюу нар буруу эрчилсэн байвал сөрөг болохыг бурхан чөтгөр хоёроор зүйрлэж хэлсэн байна.

Нар зөв
Бурхан



Хуй



Нар буруу
Чөтгөр

Монгол эсгий туургатан нарны явдал хийгээд илчийг хэрхэн танин мэдэж, яаж ашиглаж ирсний тухай ярилцъя.

Төв Азийн өндөрлөгт орших монгол туургатан бол өөрийн амьдрал ахуйдаа нарны илчийг шингээн авдаг сэтгэлгээ нэн эртнээс хөгжсөн ард түмэн юм. Тэд “нар зөв, нар буруу” хэмээх нарны илчийг шингээх, эс шингээх утгатай хэллэг буй болгожээ. Нарны илчийг бодит амьдрал ахуйд нар зөв горимоор шингээдэг, нар буруу горимоор эс шингээдэг болох нь судалгаа хийх тусам үнэмшигдэж байна. Монголч эрдэмтэд наран саран хоёрыг танин мэдээд нар бол гэрэлтэй, илчтэй, сар бол сүүдэртэй, илчгүй гэсэн ёгт олон нэрийг өгсөн байх юм. Жишээ нь:

Наран:

1. Халуун гэрэлт
2. Өдөр болгогч
3. Гэрэл гаргагч
4. Лянхуан садан

Саран:

1. Цагаан гэрэлт
2. Шөнийн эзэн
3. Сүүдэр биет
4. Лянхуан дайсан гэх мэт. Энэ

нь нар сарны илчийг ихэд танин мэдсэний гэрч болж байна. Монгол хүнээс нарны илчийг амьдралдаа шингээх, эс шингээх олон тохиолдол байгааг авч үзье.

* МУИС-ийн Монгол хэл соёлын сургууль

НЭГ. Гэр барих, буулгахад нар зөв, нар буруу гэх горим баримтална. Гэр барихад нар зөв үйлдлээр нарны илчийг даллан шингээж, барих дэс тогтооно. Гэр буулгахад нар буруу үйлдлээр нарны илчийг эс шингээж, буулгах дэс тогтооно.

1.1. Хана дугуйлах

Баруун хацавчны хананаас эхлэн, нар зөв дугуйлж нарны илчийг шингээнэ.

Хана буулгах

Зүүн хацавчны хананаас эхлэн, нар буруу буулгаж нарны илчийг эс шингээнэ.

1.2. Унь өлгөх

Тотгоны унинаас эхлэн, нар зөв нарны илчийг шингээж өлгөнө.

Унь буулгах

Тотгоны унинаас эхлэн, нар буруу нарны илчийг эс шингээж буулгана.

1.3. Бүрээс нөмөргөх

Гэрийн туурга зэрэг бүх бүрээсийг баруунаас зүүн тийш буюу нар зөв тойруулж, нарны илчийг шингээж нөмөргөнө.

Бүрээс буулгах

Гэрийн туурга зэрэг бүрээсийг нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээж буулгана.

1.4. Бүс татах

Хаалганы баруун яс модны оосроос эхлэн уяж, нар зөв тойруулж, нарны илчийг шингээж, бүс татна.

Бүс тайлах

Хаалганы зүүн яс модноос бэхэлсэн бүсний үзүүрийг эхлэн тайлж, нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээн, бүс тайлна.

1.5. Өрх татах

Зүүн хацавчнаас бэхэлсэн өрхний оосрыг эхлэн тайлж, нар зөв тойрч, нарны илчийг шингээж, өрх татна.

Өрх бүтгээх

Гэрийн чанх хойноос нар буруу тойрч, нарны илчийг эс шингээж өрх бүтгээнэ.

1.6. Хаяавч татах

Баруун хаяанаас эхлэн, нар зөв тойруулж, нарны илчийг шингээн, хаяавч татна.

Хаяавч эвхэх

Зүүн хаяанаас эхлэн, нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээн, хаяавч эвхэнэ.

1.7. Толговч барих

Хана, унь хоёрын уулзварт баруун хацавчнаас эхлэн, толговчийг нар зөв тойруулж, нарны илчийг шингээгээд, барина.

Толговч эвхэх

Зүүн хацавчнаас эхлэн, толговчийг нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээж, эвхэнэ.

1.8. Хөшиг татах

Баруун хацавчнаас эхлэн, нар зөв тойруулан, нарны илчийг шингээж, хөшиг татна.

Хөшиг тайлах

Зүүн хацавчнаас эхлэн, нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээж, хөшиг тайлна.

Монголчууд гэр барихдаа нар зөв горимоор нарны илчийг шингээж, гэр буулгахдаа нар буруу горимоор нарны илчийг эс шингээдэг болохыг дээрхи жишээ баримт харуулж байна.

ХОЁР. Монгол зан үйлд нар зөв, нар буруу хэмээх горимыг баримтлана.

2.1. Овоо тахих

“Овооны их таньдаа, олзны их маньдаа” хэмээн тахил үг хэлж, нар зөв гурвантаа тойрч, нарны илчийг шингээж, идээ будаа өргөж, чулуу нэмнэ. Монгол нутагт буй олон зуун овоог зорчигчид ийнхүү э

2.2. Оршуулга

Монгол оршуулгын үед шарил цогцсыг хүндэтгэж оршуулж буй хүмүүс насны эрэмбээр цуварч, нар зөв гурвантаа тойрцгоож, нарны илчийг шингээж, эмгэнэл илэрхийлдэг.

2.3. Хурим

Хурим найрын зан үйлд нар зөв, нар буруу гэх горим баримтална. Монгол хурмын бэртэй холбоотой зан үйлд нар зөв, нар буруугийн горим ихэд баримталж иржээ. Тухайлбал:

Бэр буулгах үед бэрийн талын хот хийгээд бас хүргэний хотыг нар зөв гурвантаа тойрох ёс гүйцэтгэнэ. (2:70, 172) Мөн “Бэр буулгаж ирээд тариа будаагаар сар зөв буюу нар буруу эргэсэн чиглэл бүхий эм галтай хас хийж, заасан цагаан эсгий дээр хасын өмнө бэрийг сөхрүүлж суулгадаг ёс байдаг”. (3:153-154) Ийнхүү шинэ бэрийн омгийг нар буруу горимоор номхруулна.

Хүннү улсын үеэс монголчууд нарны илчийг амьдрал ахуйдаа шингээн авч байсан нэгэн баримт бол Модун шаньюй Хан улсын эзэн хаанд илгээсэн бичигтээ: “Тэнгэр газрын ивгээлээр тавигдсан наран саранаас тэтгэмжтэй Хүннү” (4:07) хэмээн эрхэмсгээр бичсэн явдал юм. Басхүү хурим найрын гурван дугарааг найрын дарга, сөнч нарын зөвшөөрлөөр нар зөв аягалах зэрэг горим олон байна.

2.4. Тахилга тайлга

Энэ зан үйлийн үед нар зөв горимыг ихэвчлэн баримтлана. Монгол галын тахилгын үед “Дөрвөн галтай нар зөв эргэсэн үйлчлэл бүхий эр хас тулган дотроо улаан будгаар буюу зосоор зурж, түүн дээрээ шатах мод түлээг тавьж шатаадаг” (3:153-154) байна. Эрдэмтэн П.Хорлоо “...Гэрийн эзэн өвчүүг өргөн барьж, нар зөв гурвантаа хурайлж галд өргөж, галын тэнгэрийн заллага айлтгана”. (5:178) гэжээ. Ийнхүү гал тахих зан үйлд нар зөвийн горимыг баримталж байна.

2.5. Золгох

Монгол хүн цагаан сарын золголгын үед хамгийн ахмад настнаас эхлэн нар зөв тойрч, нарны илчийг шингээж золгоно. Хэрэв хадаг барин золговол, баруун гарынхаа ариун хурууг дотор талаас нь нар зөв хадгаар ороогоод, чигчий хуруутай тал руу доош унжуулж золгоцгооно.

2.6. Бөх барилдах, морь уралдах

Давсан бөх тахимаа авч, төрийн далбааг нар зөв тойрч, нарны илчийг шингээж, хийморио сэргээнэ. Унасан хүүхэд, уралдах хурдан морь наадмын талбайг нар зөв гурвантаа хүүхдийн гийнгоон дуунд тойрч нарны илчийг шингээж урмаа сэргээнэ. Мөнхүү айргийн тавд давхисан хурдан морьдыг төрийн далбаа намируулсан цоллогч нар зөв наадмын талбайг тойруулж, нарны илчийг шингээн түмнийг баясгана.

2.7. Гороолох

Бурхны шашны ёсоор хот хүрээ, гэр орон, уул усаа нар зөв тойрч, нарны илчийг шингээж, буян хураана.

2.8. Даллага авах

Бурхны шашны ёсоор ном айлтгуулж, даллага хурайлахад идээ будаа, арвай тариа зэргийг хоёр гардаж, нар зөв гурвантаа хурайлж, нарны илчийг шингээж, хэшиг хураана. Эрдэмтэн Л.Түдэв *“Даллага далласны дараа үнс хогоо ерийн хаях цээртэй. Нар зөв гурав эргүүлж хаяна”*. (1:55) гэжээ.

ГУРАВ. Монгол аж төрөх ёсонд нар зөв ба нар буруугийн горимыг баримтлана.

3.1. Хувцас өмсөх

Монгол хүн хувцас өмсөхөд нар зөв ба нар буруу горим баримталж, нарны илчийг шингээдэг.

- Дээлийнхээ баруун ханцуйг эхлэн углаж, нар зөв нөмөрч, нарны илчийг шингээж, зүүн ханцуйг эцэст нь углана. Зүүн ханцуйнаас эхэлж, нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээн дээлээ тайлна.

- Бүсээ нар зөв ороож, нарны илчийг шингээж бүсэлнэ. Бүсээ нар буруу эргүүлж, нарны илчийг эс шингээж тайлна. Тэгээд зангидаж тавина.

- Тэлээг нар зөв тойруулж, нарны илчийг шингээж тэлээлнэ. Тэлээг нар буруу эргүүлж, нарны илчийг эс шингээж тайлна.

- Хүзүүний ороолтыг нар зөв ороож, нарны илчийг шингээнэ. Нар буруу тойруулж, нарны илчийг эс шингээн тайлна.

3.2. Эрч оруулах, хариулах үйл

Аливаа юмыг эрчлэх, эрчийг хариулахад нар зөв ба нар буруу горимоор үйлдэнэ.

- Эрэгтэй эмэгтэй хүний гээг үсийг гөрөх сүлжихэд нар зөв эргүүлж, нарны илчийг шингээнэ. Гээгийг нар буруу эргүүлж, нарны илчийг эс шингээн задална.

- Дээс, хуйв зэргийг томох алгахдаа нар зөв эрчилж, нарны илчийг шингээнэ. Эрчийг гаргахдаа нар буруу эргүүлж, нарны илчийг эс шингээнэ.

- Хурдан морины гөхөл, сүүлний уяаг нар зөв эргүүлж, нарны илчийг шингээнэ. Тайлахдаа нар буруу эргүүлж, нарны илчийг эс шингээнэ.

- Бугуйл, гэрийн бүс, татлага зэргийг эвхэхдээ тохой гарын сарвууд нар зөв эргүүлж, нарны илчийг шингээнэ. Эвхээсийг гаргахдаа нар буруу тайлж, нарны илчийг эс шингээнэ.

3.3. Ажил үйл

Монгол хүн зарим ажлыг эрэмбэ дараатай үйлдэхэд нар зөвийн горимыг баримтлана.

- Айраг архи, цай цуй аягалах, барихад нар зөв түгээнэ.
- Бэлэг сэлэг, шан харамж тараахад нар зөв хүртээнэ.
- Арвай буудай тээрэмдэхэд тээрмийн чулууг нар зөв эргүүлнэ.
- Зулын голыг нар зөв имэрнэ.
- Тараг, хоол идсэн аягыг нар зөв долооно.

- Айраг бүлэх, хоол хутгахад нар зөв горим хэрэглэнэ гэх мэт.

Энэ мэтээр монгол аж төрөх ёсонд нар зөвийн горим үйлчилж, нарны илчийг шингээн авч байдаг уламжлал бий.

Монголчууд нар зөв эргэсэн үйлдэл бүхий тогтоц бүтэцтэй зүйлд эерэг сайн ханддаг сэтгэлгээтэй ард түмэн юм. Жишээ нь:

- Өлзий хутгийн найман билгийн нэг наран зөвшөөхүй эргэсэн цагаан лавай
- Хуй салхины нар зөв эрчилсэн эргүүлэг.
- Хүн малын үсний нар зөв эргэсэн эргүүлэг.
- Усны нар зөв эргэсэн эргүүлэг гэх мэт.

Дүгнэн хэлбэл, монгол туургатан нарны илчийг нар зөв эргэх хөдлөлөөр шингээж, нар буруу эргэх хөдлөлөөр нарны илчийг эс шингээж аж төрсөөр иржээ. Ямарваа тойрох, тойруулах үйлийн дэс эрэмбийг тогтооход нар зөвийн горим үйлчилж, номхотгох, хариулах үйлд нар буруу эргэх хөдлөлийг үйлдэж нарны илч эрчмийг авсаар байна.

SUMMARY

To sum up, the Mongol race has lived by absorbing solar heat from its clockwise movement though exuding it by counter-clockwise motion. Order of clockwise proceeds while defining the sequence of rotation or cycle of any act while counter-clockwise motion works in taming and repaying acts.

НОМ ЗҮЙ

- Л. Түдэв “Аман хууль” УБ. 2000. 106 дахь тал
 Ц. Баасандорж, А. Очир “Ойрад хуримын ёс” УБ. 2005. 70, 172 дахь тал
 Ж. Цолоо “Монгол хэлний нутгийн аялгуу. Үгийн сан”. 1. УБ. 1997. 153-154 дэх тал
 Н. Ишжамц “Монголын төр ёс, нүүдэл иргэнийл, сэргэн мандалтын асуудал” Mongolica UB. 1991-1992 vol. 2/23, 3/24. Pp 07
 П. Хорлоо “Монгол ардын зан үйлийн хэлхээ” УБ. 1999. 178 дахь тал